



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 12 сарын 08 өдөр

Дугаар А/386

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэний нисэхийн ерөнхий газрын Авлигын эсрэг баримтлах дунд хугацааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 02 дугаар сарын 15-ны дотор батлуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албанд даалгасугай.

3.Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тогтоосон хугацаанд тайлагнахыг холбогдох нэгжийн дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албанд үүрэг болгосугай.


ДАРГА



Ч.МӨНХТУЯА

17120 1774

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн
А/38 дугаар тушаалын хавсралт



АВЛИГЫН ЭСРЭГ БАРИМТЛАХ ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Хэрэгцээ шаардлага, тулгамдаж буй асуудал

Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12-т "бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээ авах" үүргийг төрийн байгууллага бүрд ногдуулсан байдаг. Төрийн байгууллага авлигаас ангид байх, түүнээс урьдчилан сэргийлэх, авлига үүсэх шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авах үүрэгтэй бөгөөд түүний хэрэгжилтэд үнэлгээ хийж, өнөөгийн нөхцөл байдлаа тодорхойлж, цаашид авах арга хэмжээ тогтоох шаардлагатай байдаг.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолоор 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарлаж, авлигатай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлэх ажиллагаа, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг багасгах, нийтийн албанд танилын хүрээгээр томилогдохгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, цахимжилтыг эрчимжүүлэх, бүх төрлийн сонгон шалгаруулалтыг нээлттэй болгохыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт үүрэг болгосон билээ.

Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хугацаа 2023 онд дууссан бөгөөд тус байгууллага тус хөтөлбөрт тусгагдсан 4 зорилтын 14 арга хэмжээг хариуцаж, 82.7%-тай хэрэгжүүлсэн. ИНЕГ-ын нэгжүүдийн ажлын уялдаа, холбоо сул байснаас тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээний хэрэгжилт зорилтот түвшиндээ хүрч хэрэгжээгүй.

Мөн Авлигатай тэмцэх газрын 2021 онд хийсэн "Авлигатай тэмцэх газраас хийсэн шударга байдлын үнэлгээ"-гээр 69.7 оноо авсан бөгөөд 2019 оны үнэлгээтэй харьцуулахад 3.1 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Авлигатай тэмцэх газраас хийсэн шударга байдлын үнэлгээг 3 чиглэлээр авахад байгууллагын гадаад шударга байдлын үнэлгээ-71.4 оноо, байгууллагын дотоод шударга байдлын үнэлгээ-78.3 оноо, бодлогод оролцогчдын үнэлгээ /Дээд байгууллагын төлөөлөл, бодлого боловсруулагч болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, холбоодын төлөөлөл, аудитор, хяналтын ажилтан, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч, эрдэмтэн, судлаачдын төлөөллийг хамруулсан/ 59.5 авсан байна. Үнэлгээний дүнгээс харахад удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлийг болон ашиг сонирхлын зөрчлийг илтгэдэг, тэвчдэггүй соёлыг төлөвшүүлэх, авлигын эсрэг тогтолцоог оновчтой бүрдүүлэх, авлигыг хянах механизм,

дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах, хүний нөөцийг ил тод сонгон шалгаруулалтаар бүрдүүлэх, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /2023-2030 он/-ийг баталсан бөгөөд хөтөлбөрийн гол зорилго нь үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн бүх түвшинд шударга эрхэмлэсэн хандлагыг төлөвшүүлэхэд оршиж байна. Мөн хөтөлбөрийн зорилт 2.6.-д “Салбарын эрсдэлийг оновчтой тодорхойлж, түүнд чиглэсэн арга хэмжээг үе шаттайгаар, цогц байдлаар хэрэгжүүлнэ.” гэж заасан байна. Мөн эрсдэлд суурилсан авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангахыг Авлигатай тэмцэх газар зөвлөж байгаа билээ.

Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллаж байгаа ч хэрэгжүүлсэн ажлуудыг болон бодлого, дэг журмын талаарх сурталчилгаа хангалтгүй түвшинд байгааг ажилтнуудаас авсан судалгаагаар тогтооёдож байна.

Тус байгууллагын 2030 онд хүртэл баримтлах бодлогыг тодорхойлохдоо байгууллагын авлигын эрсдэлийн үнэлгээг хийж, 2016 онд батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн холбогдох заалтын хэрэгжилт болон Авлигатай тэмцэх газрын 2021 онд хийсэн “Авлигатай тэмцэх газраас хийсэн шударга байдлын үнэлгээ”-ний зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, цаашдын зорилт, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон.

Иймд цаашид удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлийг болон ашиг сонирхлын зөрчлийг илтгэдэг, тэвчдэггүй соёлыг төлөвшүүлэх, авлигын эсрэг тогтолцоог оновчтой бүрдүүлэх, авлигатай тэмцэх талаар ажилтнуудын мэдлэгийг дээшлүүлэх, зан, үйл хандлагыг өөрчлөх, шударга эрхэмлэсэн хандлагыг төлөвшүүлэх, байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг сайжруулах, хүнд суртал үүсгэж байгаа дүрэм, журмыг хялбаршуулах чиглэлээр цогц арга хэмжээ авах шаардлагатай байна. Иймд 2024-2030 онд авлигын эсрэг баримтлах бодлогыг холбогдох бодлогын баримт бичигтэй уялдуулан боловсрууллаа.

1.2.Нэр томьёо:

“хөтөлбөрийн зорилго” гэж бодлого, төлөвлөлтийн уялдааг хангасан, хүрч болохуйц эерэг өөрчлөлтийг;

“хөтөлбөрийн үр нөлөө” гэж хөтөлбөрийг хэрэгжүүлснээр бий болох эерэг өөрчлөлтийг;

“үйл ажиллагаа” гэж хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн оновчтой, хэмжигдэхүйц, тодорхой хугацаанд хүрч болохуйц арга хэмжээг;

“суурь түвшин” гэж хөтөлбөрийн төслийг боловсруулах үеийн шалгуур үзүүлэлтийн тоон болон чанарын утгыг;

“шалгуур үзүүлэлт” гэж хөтөлбөрийн хэрэгжилтийн үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжихээр төсөлд заасан тоон болон чанарын үзүүлэлтийг;

“зорилтот түвшин” гэж хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжиж дуусахад хүрэхээр хүлээгдэж байгаа өөрчлөлтийг төсөлд тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн тоон болон чанарын утгыг;

“хяналт-шинжилгээ” гэж хөтөлбөрийн зорилго, зорилтын хэрэгжилтийн явцыг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хянах, мэдээлэх тасралтгүй үйл ажиллагааг;

“үнэлгээ” гэж хөтөлбөрийн зорилго, зорилтын хэрэгжилтийг төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн эсэхэд дүн шинжилгээ хийж өгсөн үнэлэлтийг;

“үр дүнд суурилсан явцын үнэлгээ” гэж хяналт-шинжилгээний мэдээлэлд үндэслэн зорилтот түвшинд хүрч байгаа эсэхэд үнэлгээ хийх, хүрээгүй бол шалтгаан нөхцөлийг тодорхойлж, үр дүнг сайжруулах дүгнэлт, зөвлөмж гаргах үйл ажиллагааг;

“үр дүнд суурилсан эцсийн үнэлгээ” гэж хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа хэрэгжилтийг үнэлж, үр дүн, үр ашиг, үр нөлөөг тодорхойлон цаашид тухайн чиглэлээр бодлого боловсруулан хэрэгжүүлэх, эсхүл зогсоох талаар дүгнэлт, зөвлөмж гаргах үйл ажиллагааг;

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

2.1.Хөтөлбөрийн зорилго

Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж, байгууллагын бүх түвшинд шударга байдлыг эрхэмлэсэн зөв хандлагатай хамт олон болоход хөтөлбөрийн зорилго оршино.

2.2.Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна:

Зорилт 1.Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлийг шинэ шатанд гаргана.

Зорилт 2.Хүний нөөцийн бодлого, чиглэлийг тодорхойлж, үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.

Зорилт 3.Авлигын эсрэг тогтолцоог оновчтой бүрдүүлэх, авлигыг хянах механизм, дотоод хяналтын үйл ажиллагааг эрс сайжруулна.

Зорилт 4.Ашиг сонирхлын зөрчлийг илтгэдэг, түүнтэй тэмцэх зан үйлийг өөрчлөх, зөв хандлагыг ажилтнуудад төлөвшүүлнэ.

Зорилт 5.Байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгана.

Зорилт 6.Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулна.

2.3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг 2024-2030 онд хэрэгжүүлнэ.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1.“Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлийг шинэ шатанд гаргана.” хөтөлбөрийн 1 дүгээр зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн:

Үйл ажиллагаа:

3.1.1.байгууллагын дээд болон дунд шатны менежерүүд биеэр үлгэрлэх, хариуцлага үүрэх, манлайлах тогтолцоог нэвтрүүлж, удирдлагууд авлигатай тэмцэх үйл ажиллагааны ач холбогдлыг тайлбарлан таниулах сургалтыг жил бүр ажилтнуудад зохион байгуулна.

3.1.2.байгууллагын үнэт зүйлийг нийт ажилтнуудад танилцуулж, үнэт зүйл, ёс зүйг ажлын байранд төлөвшүүлэх арга хэмжээ авна.

3.1.3.байгууллага дахь авлигын эсрэг соёлыг төлөвшүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авна.

3.1.4.авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаалд ажиллаж байгаа ажилтнуудад чиглэсэн авлигаас сэргийлэх зарчим боловсруулах, дүрэм, журмыг нягтлан шалгах, ажлын байрыг сэлгүүлэх, зөвлөмж өгөх, үр дүнг нийт ажилтнуудад танилцуулна.

3.1.5.Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран ажиллах чиглэлийг тогтоож, тэдгээрийг оролцоог бий болгож, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлж, хэрэгжүүлнэ.

- 3.1.6. Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-тэй уялдуулан 2024-2030 онд баримтлах бодлого, арга хэмжээг төлөвлөж, байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд авлигын эсрэг авах арга хэмжээг тусгаж, хэрэгжүүлнэ.
- 3.1.7. эрсдэлийн шинжилгээг 2 жил тутамд хийж, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж хэрэгжилт, үр дүнг байнга хянаж, нийтэд мэдээлнэ.
- 3.1.8. худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр өгөөжийг тооцдог болох, энэ талаарх мэдээллээр хэрэглэгчдийг хангана.

Хүрэх үр дүн.

- Удирдлагууд авлигатай тэмцэх үйл ажиллагааны ач холбогдлыг тайлбарлан таниулах, манлайллын сургалтыг жил бүр нийт ажилтнуудад хийсэн байна.
 - Хөдөлмөрийн дотоод журамд удирдах албан тушаалтан биеэр үлгэрлэх, хариуцлага хүлээх талаар холбогдох заалтыг тусгасан байна.
 - Байгууллагын үнэт зүйл, ёс зүйг ажлын байранд төлөвшүүлэх чиглэлээр сургалт, арга хэмжээг зохион байгуулсан байна.
 - Авлигын эсрэг 2024-2030 онд баримтлах бодлого, арга хэмжээг төлөвлөж, байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлсэн байна.
 - Байгууллагын авлигын эрсдэлийн шинжилгээг 2 жил тутамд хийлгүүлж, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.
 - Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр өгөөжийг тооцдог тогтолцоонд шилжсэн байна.
 - Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлж, хамтран ажиллаж, үр дүнг гаргасан байна.
- 3.2. “Хүний нөөцийн бодлого, чиглэлийг тодорхойлж, үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.” хөтөлбөрийн 2 дугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн:

Үйл ажиллагаа:

- 3.2.1. цалин хөлсний бодлогыг боловсронгуй болгоно.
- 3.2.2. хүний нөөцийн бодлогыг судалгаа, шинжилгээнд тулгуурлан шинэчлэн боловсруулах, боловсруулсан төслийг ажилтнуудад танилцуулж, санал авах, хэрэгжилтийн талаарх мэдээллээр ажилтнуудыг хангана.
- 3.2.3. ажлын байрны шинжилгээ хийж, сургалтын хэрэгцээ шаардлагад тулгуурлан сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, сургалтын үр өгөөжийг тооцдог тогтолцоог бүрдүүлнэ.

- 3.2.4. “Сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулах журам”-ыг хэрэгжүүлэх, сул ажлын байрны зарыг нийтэд мэдээлэх, сул ажлын байрыг сонгон шалгаруулалтаар бүрдүүлдэг тогтолцоог бүрэн нэвтрүүлнэ.
- 3.2.5. байгууллагын зүгээс үзүүлдэг тэтгэлэг, дэмжлэгт хамрагдах асуудлыг нээлттэй, нийтийн оролцоог хангасан байдлаар зохион байгуулна.
- 3.2.6. Албан тушаалын тодорхойлолтуудыг эрх бүхий албан тушаалтны тушаалаар баталж, албан тушаалтанд зориулж өөрчилдөггүй тогтолцоонд шилжинэ.
- 3.2.7. Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмыг шинэчилж, хэрэгжүүлж, үнэлгээний тайланг тухай бүр ил тод мэдээлнэ.

Хүрэх үр дүн.

- Бүтээмжид тулгуурласан цалин хөлсний бодлогыг боловсруулж, мөрдсөн байна.
 - Хүний нөөцийн бодлогыг оновчтой тодорхойлж, хэрэгжүүлсэн байна.
 - “Сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулах журам”-ыг үйл ажиллагаандаа байнга мөрддөг болсон байна.
 - Сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, мөрдөж, сургалтын үр дүнг тооцдог механизмд бүрэн шилжсэн байна.
 - Албан тушаалын тодорхойлолтыг албан тушаалтанд зориулж өөрчилдөггүй тогтолцоог хэрэгжүүлсэн байна.
 - Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг бодит үнэлж, үнэлгээний тайланг нийтэд мэдээлдэг болсон байна.
- 3.3 “Авлигын эсрэг тогтолцоог оновчтой бүрдүүлэх, авлигыг хянах механизм, дотоод хяналтын үйл ажиллагааг эрс сайжруулна.” хөтөлбөрийн 3 дугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн:

Үйл ажиллагаа:

- 3.3.1. шүгэл үлээгчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх, авлига авсан талаарх үйлдлийг мэдээлэх боломжийг бүрдүүлнэ.
- 3.3.2. байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа нийтэд хамааралтай дүрэм, журмуудад шинжилгээ хийж, хүнд суртал, чирэгдлийг багасгах, хялбаршуулах арга хэмжээ авна.
- 3.3.3. тусгай зөвшөөрөл олгох ажлыг цахимжуулна.
- 3.3.4. авлигад өртөх хамгийн их эрсдэлтэй ажил үйлчилгээгээр тодорхойлогдсон сул орон тоог нөхөж буй байдал, худалдан авах ажиллагаа, тусгай зөвшөөрөл

олгож буй байдалд төлөвлөгөөт бус гэнэтийн дотоод аудит, хяналт шалгалтыг хийж, зөрчил дутагдлыг засаж залруулах арга хэмжээ авч, мэдээлнэ.

3.3.5.байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан дотоод аудит, хяналт шалгалт хийдэг тогтолцоонд шилжих;

3.3.6.Ашиг сонирхлын зөрчлийн хяналтыг жил бүр хийнэ.

3.3.7.хяналт шалгалтын мэдээллийг олон нийтэд хуулийн хүрээнд нээлттэй байлгах /цахим хуудсаар, мэдээллийн самбараар/, зөрчлийг арилгуулах, зөвлөмж, шаардлага хүргүүлэх, сургалт явуулах, хариуцлага тооцох арга хэмжээ авч, мэдээллийг нийт ажилтнуудад мэдээлнэ.

3.3.8.“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлнэ.

3.3.9.Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, хүндрэл бэрхшээлийн тодорхойлох судалгааг жил бүр авч, үнэлэлт дүгнэлт хийж, цаашид авах арга хэмжээг тодорхойлно.

3.3.10.Ажилтнуудаас ахиц дэвшлийг үнэлэх судалгааг жил бүр авна.

3.3.11.Тус байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлыг судалж, дүн шинжилгээ хийж, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй журмуудад өөрчлөлт оруулна.

Хүрэх үр дүн:

- Шүгэл үлээгчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлж, холбогдох зохицуулалтыг журамд тусгасан байна.
- Тусгай зөвшөөрлийг цахимд шилжүүлсэн байна.
- байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа нийтэд хамааралтай дүрэм, журмуудад шинжилгээ хийж, хүнд суртал, чирэгдлийг багасгах, хялбаршуулах арга хэмжээ авсан байна.
- “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг үе шаттай хэрэгжүүлсэн байна.
- Эрсдэлд суурилсан дотоод аудит, хяналт шалгалт хийдэг тогтолцоонд шилжиж, аудит, хяналт шалгалтын тайланг нийтэд мэдээлдэг болсон байна.
- Судалгаануудыг тодорхой давтамжтай авч, цаашид авах арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлсэн байна.

3.4. “Ашиг сонирхлын зөрчлийг илтгэдэг, түүнтэй тэмцэх зан үйлийг өөрчлөх, зөв хандлагыг ажилтнуудад төлөвшүүлнэ.” хөтөлбөрийн 4 дүгээр зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн:

Үйл ажиллагаа:

- 3.4.1. авлигын хор уршиг, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх, авлигын талаар мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах тодорхой бүлгүүдэд чиглэсэн сургалтын концепцыг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 3.4.2. шударга ёсны талаар сургалтыг нийт ажилтнуудад зохион байгуулж хэвших, зөв амьдрах хэв хаягийг хэвшүүлэхэд нийт ажилтнуудыг татан оролцуулах, арга хэмжээ зохион байгуулна. / хэлэлцүүлэг, зөвлөгөөн, ярилцлага, нэвтрүүлэг/
- 3.4.3. шинэ ажилтны сургалтын хөтөлбөрт авлига, шударга ёсны сургалтыг тусгаж, хэрэгжүүлнэ.
- 3.4.4. ёс зүйн дүрмийг нийт ажилтнуудад танилцуулах сургалт зохион байгуулна.
- 3.4.5. байгууллагын үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байлгахад чиглэсэн ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зураг хуудас, гарын авлага, брошюр) бэлтгэж, олон нийтэд хүргэнэ.

Хүрэх үр дүн:

- Ажилтнуудыг сургалтад хамруулсан байна.
- Жилд 2-оос доошгүй сурталчилгааны материал, шторк, зураг хуудас, гарын авлага, брошюр боловсруулсан байна.
- Ёс зүйн дүрэм, шударга ёсны талаар сургалтыг нийт ажилтнуудад жил бүр зохион байгуулж, мэдээллээр хангасан байна.
- Шинэ ажилтны сургалтын хөтөлбөрт шударга ёс, авлигын хор нөлөө, түүнтэй хэрхэн тэмцэх талаар тусгаж, хэрэгжүүлсэн байна.

3.5. “Байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгана.” хөтөлбөрийн 5 дугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн:

Үйл ажиллагаа

- 3.5.1. байгууллагын цахим хуудсыг энгийн, иргэд мэдээллийг хялбар авдаг байхаар шинэчилнэ.
- 3.5.2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах, байгууллагын цахим хуудсыг ажиллуулах, журам, мэдээллийг байршуулах ажилтнуудын жагсаалт, хугацааг батлах, мэдээллийг тогтмол шинэчилдэг тогтолцоог бий болгох, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
- 3.5.3. Мэдээллийн урсгалыг эрчимжүүлэх, ажлын уялдаа холбоог сайжруулна.

3.5.4. удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэрийг цахим хуудсанд байршуулна.

Хүрэх үр дүн:

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангасан байна.
- Байгууллагын цахим хуудсыг шинэчилж, баяжуулалтыг тогтмол хийдэг болсон байна.

3.6. “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулна.” хөтөлбөрийн 6 дугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн:

Үйл ажиллагаа:

3.6.1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг мөрдөж ажиллана.

3.6.2. хориглолт, хязгаарлалтыг мөрдөж ажиллах талаар ХАСХОМ гаргадаг ажилтнуудад бичгээр зөвлөмж хүргүүлнэ.

3.6.3. давхар ажил эрхлэлтийн жагсаалт, хамаарал бүхий этгээд, садан төрлийн судалгааг жил бүр шинэчилнэ.

3.6.4. хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох, гаргасан шийдвэрийн талаар албан хаагчдад мэдээлнэ.

Хүрэх үр дүн:

- Хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг мөрдөж, ашиг сонирхлын зөрчил гаргадаггүй болсон байна.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

4.1. Хөтөлбөрийн үр нөлөө

4.1.1. Авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулснаар авлигын гэмт хэрэгт өртөж болзошгүй аюулаас хамгаалж, түүнээс сэргийлэх боломж бүрдэнэ.

4.1.2. Байгууллагын ажилтнуудад авлигын хор уршиг, түүнтэй тэмцэх, зан үйлийг өөрчлөх талаар мэдээлэл, сургалт, сурталчилгааг явуулж, шударга байдлыг эрхэмлэсэн зөв хандлагыг бий болгоно.

4.2. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

Хөтөлбөрийн хэрэгжилтийн болон үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэх бөгөөд 2023 онд хийсэн авлигын эрсдэлийн үнэлгээний үр дүнг суурь үзүүлэлт болгон ашигласан.

	Хөтөлбөрийн зорилго, зорилтын хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн		
			Суурь үзүүлэлт /2021, 2023 он/	2026 он	2030 он
Зорилго	Авлига, албан тушаалын гэмт хэрэг гардаггүй, байгууллагын бүх түвшинд шударга байдлыг эрхэмлэсэн зөв хандлагатай хамт олон бий болох	Авлигатай тэмцэх газраас хийсэн шударга байдлын үнэлгээний харьцуулалт, онооны өсөлт, бууралт	69.7оноо	80 оноо	90 оноо
		Эрсдэлийн үнэлгээний харьцуулалт	2023 онд 9 бүлэг үзүүлэлтээр авсан судалгааны дүн	9 бүлэг үзүүлэлтээр авсан судалгааны дүнтэй харьцуулна	9 бүлэг үзүүлэлтээр авсан судалгааны дүнтэй харьцуулна
Зорилт 1	Удирдлагууд авлигатай тэмцэх үйл ажиллагааны ач холбогдлыг тайлбарлан таниулах, манлайллын сургалтыг жил бүр нийт ажилтнуудад хийсэн байна.	Сургалтын тоо	0	3	3
	Байгууллагын үнэт зүйл, ёс зүйг ажлын байранд төлөвшүүлэх чиглэлээр сургалт, арга хэмжээг зохион байгуулсан байна.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	0	3	3

	Хөдөлмөрийн дотоод журамд удирдах албан тушаалтан биеэр үлгэрлэх, хариуцлага хүлээх талаар холбогдох заалтыг тусгасан байна.	Заалтыг тусгасан эсэх Тийм-1 Үгүй-0	0	1	-
	Авлигын эсрэг 2024-2030 онд баримтлах бодлого, арга хэмжээг төлөвлөж, байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлсэн байна.	Дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлсэн эсэх Тийм-1 Үгүй-0	0	1	1
	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр өгөөжийг тооцдог тогтолцоонд шилжсэн байна.	Үр өгөөжийг тооцдог тогтолцоонд шилжсэн эсэх Тийм-1 Үгүй-0	0	1	-
	Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлж, хамтран ажиллаж, үр дүнг гаргасан байна.	Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон эсэх Тийм-1 Үгүй-0	1		
		Байгуулсан хамтын ажиллагааны гэрээний тоо	0	3	3

		Гэрээний хэрэгжилтийг үнэлж, үр дүнг тооцсон эсэх Тийм-1 Үгүй-0	0	3	3
	Байгууллагын авлигын эрсдэлийн шинжилгээг 2 жил тутамд хийлгүүлж, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.	Авлигын эрсдэлийн шинжилгээг хийж, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх Тийм-1 Үгүй-0	1	1	1
Зорилт 2	Бүтээмжид тулгуурласан цалин хөлсний бодлогыг боловсруулж, мөрдсөн байна.	Бүтээмжид тулгуурласан цалин хөлсний бодлоготой болсон эсэх Тийм-1 Үгүй-0	0	1	-
	“Сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулах журам”-ыг үйл ажиллагаандаа байнга мөрддөг болсон байна.	Сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулах журам”-ыг үйл ажиллагаандаа байнга мөрддөг эсэх Тийм-1 Үгүй-0	0	1	1
	Сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, мөрдөж, сургалтын үр дүнг тооцдог механизмд бүрэн шилжсэн байна.	Сургалтын үр дүнг тооцдог механизмд бүрэн шилжсэн эсэх Тийм-1 Үгүй-0	0	1	1

	Албан тушаалын тодорхойлолтыг албан тушаалтанд зориулж өөрчилдөггүй тогтолцоог хэрэгжүүлсэн байна.	Албан тушаалын тодорхойлолтыг албан тушаалтанд зориулж өөрчилдөггүй тогтолцоонд мөрддөг болсон эсэх Тийм-1 Үгүй-0	0	1	1
	Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг бодит үнэлж, үнэлгээний тайланг нийтэд мэдээлдэг болсон байна.	Шинэчлэн боловсруулсан ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмын тоо	1	1	-
		Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг бодит үнэлж, үнэлгээний тайланг нийтэд мэдээлдэг болсон эсэх Тийм-1 Үгүй-0	0	1	1
Зорилт3	Шүгэл үлээгчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлж, холбогдох зохицуулалтыг журамд тусгасан байна.	Боловсруулсан журмын тоо	0	1	-
	Тусгай зөвшөөрлийг цахимд шилжүүлсэн байна.	Цахимаар олгох тусгай зөвшөөрлийн тоо	0	3	-

	Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа нийтэд хамааралтай дүрэм, журмуудад шинжилгээ хийж, хүнд суртал, чирэгдлийг багасгах, хялбаршуулах арга хэмжээ авсан байна.	Өөрчлөлт оруулсан дүрмийн тоо	0	Гүйцэтгэлээр	Гүйцэтгэлээр
	“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг үе шаттай хэрэгжүүлсэн байна.	Хамруулах чиглэлийг тогтоосон эсэх Тийм-1 Үгүй-0	0	1	-
Байгуулсан хамтын ажиллагааны гэрээний тоо		0	3	3	
Гэрээний хэрэгжилтийг үнэлж, үр дүнг тооцсон эсэх Тийм-1 Үгүй-0		0	3	3	
	Эрсдэлд суурилсан дотоод аудит, хяналт шалгалт хийдэг тогтолцоонд шилжиж, аудит, хяналт шалгалтын тайланг нийтэд мэдээлдэг болсон байна.	Эрсдэлд суурилсан дотоод аудит, хяналт шалгалтын тоо	0	Гүйцэтгэлээр	Гүйцэтгэлээр
Аудит, хяналт шалгалтын тайланг нийтэд мэдээлдэг болсон эсэх Тийм-1 Үгүй-0		1	1	1	
Зорилт	Ажилтнуудыг сургалтад хамруулсан байна.	Сургалтад хамруулсан ажилтнуудын хувь	30%	90%	100%

		Сургалтын концепцыг боловсруулж, мөрдсөн эсэх Тийм-1 Үгүй-0	0	1	1
	Жилд 2-оос доошгүй сурталчилгааны материал, шторк, зураг хуудас, гарын авлага, брошюр боловсруулсан байна.	Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулсан сурталчилгааны материалын тоо	2	6	6
	Ёс зүйн дүрэм, шударга ёсны талаар сургалтыг нийт ажилтнуудад жил бүр зохион байгуулж, мэдээллээр хангасан байна.	Зохион байгуулсан сургалтын тоо	3	6	6
	Шинэ ажилтны сургалтын хөтөлбөрт шударга ёс, авлигын хор нөлөө, түүнтэй хэрхэн тэмцэх талаар тусгаж, хэрэгжүүлсэн байна.	Шударга ёс, авлигын хор нөлөө, түүнтэй хэрхэн тэмцэх талаар шинэ ажилтны сургалтын хөтөлбөрт тусгаж, сургалт зохион байгуулсан эсэх Тийм-1 Үгүй-0	0	1	1
Зорилт 5	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангасан байна.	Хуулийн хэрэгжилтийн хувь	90%	100%	100%